


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ  
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,  
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН  
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



# МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ)

## ГАДААД ХУДАЛДАА (2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр)



### Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт:** Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2023 оны IV улирлын гүйцэтгэлээр **24,437.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс**

**15.0 хувь буюу 3,193.97 сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл 5,932.0 сая ам.долларын ашигтай гарсан байна.**

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	IV улирал				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	12,875.2	16,095.8	21,243.0	24,437.0	3,193.97	15.0%
-Экспорт	7,576.3	9,247.1	12,538.6	15,184.5	2,645.87	21.1%
-Импорт	5,298.9	6,848.6	8,704.4	9,252.5	548.10	6.3%
Тэнцэл	2,277.4	2,398.5	3,834.2	5,932.0	2,097.78	54.7%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2023 оны IV улирлын байдлаар гадаад худалдааны тэнцэл **5,932.0** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 2,097.78 сая ам.доллараар өсөхөд экспорт 2,645.8 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Экспорт:** Экспортын худалдаа 2023 оны IV улирлын гүйцэтгэлээр **15,184.5** сая ам.доллар болж, 2022 оны мөн үетэй харьцуулахад 2,645.8 сая ам.доллар буюу

21.1 хувиар өссөн байна.

**Импорт:** 2023 оны IV улирлын байдлаар импортын хэмжээ **9,252.5** сая ам.долларт хүрч, 2022 оны мөн үетэй харьцуулахад 548.1 сая ам.доллар буюу 6.3 хувиар өссөн байна.

### Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **86.6** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **13.4** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **13,145.6** сая ам.доллар болж, өмнөх оноос 2,602.4

сая ам.доллар буюу 24.7 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **2,038.8** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 43.5 сая ам.доллар буюу 2.2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	IV улирал				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	5,256.0	7,516.0	10,543.3	13,145.6	2,602.4	24.7	86.6
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	2,320.3	1,731.2	1,995.3	2,038.8	43.5	2.2	13.4
Нийт экспорт	7,576.3	9,247.1	12,538.6	15,184.5	2,645.9	21.1	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

### ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Монгол улс дэлхийн **64** оронд бараа экспортлосноос БНХАУ-д **82.6** хувь, Швейцар-т **9.4** хувь, Сингапурт **2.8** хувь, БНСУ-д **2.4** хувь, нийт экспортын **97.2** хувийг дээрх орнууд эзэлж байна.

Нийт экспортын **57.7** хувийг нүүрс, **17.3** хувийг зэсийн баяжмал, **4.9** хувийг алт, **2.9** хувийг төмрийн хүдэр тус тус эзэлсэн байна.

#### Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	I улирал				Өмнөх оны мөн үеэс	
		2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,395.1	1,282.5	1,453.3	1,524.8	71.5	4.9
Нүүрс	сая.тн	28.5	15.71	31.7	66.7	35.0	110.4
Төмрийн хүдэр	сая.тн	8.2	7.1	4.7	5.7	1.0	21.3
Цайрын баяжмал	мян.тн	134.1	112.6	141.2	150.5	9.3	6.6
Алт	тн	30.5	17.2	19.7	11.7	-8.0	-40.6
Түүхий нефть болон газрын тос	сая.баррель	4.1	4.3	2.6	4.7	2.1	80.8
Катодын зэс	тн	9.6	9.8	10.0	12.5	2.5	25.0
Жоншны баяжмал	мян.тн	396.7	383.8	106.3	271.1	164.8	155.0
Адууны мах	мян.тн	17.6	7.0	6.9	32.9	26.0	376.8
Өлөн гэдэс	мян.тн	1.4	1.4	1.6	1.2	-0.4	-25.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	23.4	7.6	17.4	10.0	-7.4	-42.5
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	344.0	441.4	106.3	516.2	409.9	385.6
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	49.2	66.3	78.9	39.9	-39.0	-49.4
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	85.2	77.0	76.2	59.3	-16.9	-22.2
Самнасан ноолуур	мян.тн	0.3	0.4	0.9	1.0	0.1	11.1
Бохир ноолуур	мян.тн	6.3	6.0	6.4	5.4	-1.0	-15.6
Хонины самнаагүй ноос	мян.тн	8.5	5.4	17.7	13.3	-4.4	-24.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

#### Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	IV улирал				Өмнөх оны мөн үеэс	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	1,778.0	2,899.9	2,734.8	2,625.4	-109.40	-4.0
Нүүрс	2,123.7	2,763.9	6,495.6	8,764.0	2,268.40	34.9
Төмрийн хүдэр	640.0	952.2	391.0	444.8	53.80	13.8
Цайрын баяжмал	167.7	176.4	283.3	220.0	-63.30	-22.3
Алт	1,787.7	1,004.5	1,127.4	738.0	-389.40	-34.5
Боловсруулаагүй нефть	150.9	273.4	241.8	364.7	122.90	50.8
Катодын зэс	59.3	88.5	82.6	102.5	19.90	24.1
Адууны мах	120.1	111.2	38.8	109.8	71.00	183.0
Өлөн гэдэс	33.0	14.4	21.1	125.4	104.30	494.3
Үхэр, адууны боловсруулсан шир	18.2	30.6	32.2	22.9	-9.30	-28.9
Үхэр, адууны боловсруулаагүй шир	2.3	0.8	0.91	0.65	-0.26	-28.6
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.5	0.7	0.73	1.14	0.41	56.2
Ямаа, ишигний боловсруулсан арьс	1.0	1.3	1.4	0.6	-0.80	-57.1
Самнасан ноолуур	3.1	2.4	1.6	1.5	-0.10	-6.3
Бохир ноолуур	16.9	39.9	93.1	95.9	2.80	3.0
Хонины самнаагүй ноос	185.3	253.6	308.4	264.0	-44.40	-14.4
Жоншны баяжмал	9.0	5.4	14.8	14.0	-0.80	-5.4
Нийт экспортод эзлэх хувь	93.7%	93.2%	94.7%	91.5%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 2,602.4 сая ам.доллар буюу 24.7 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:**

**1. Нүүрс:** 2023 оны IV улирлын байдлаар 66.7 сая тонн нүүрс экспортолж, 8,764.0 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 35.0 сая тонноор өссөн бол экспортын орлого мөн 2,268.4 сая ам.доллараар буюу 34.9 хувиар өссөн байна. Экспортын биет тоо хэмжээ нүүрсний экспортын орлогын өсөлтөд чухал нөлөө үзүүлсэн байна. Чулуун нүүрсний 99.3 хувийг БНХАУ руу экспортолсон байна.

**2.Зэсийн баяжмал:** 2023 оны IV улирлын байдлаар 2023 оны гүйцэтгэлээр 2,625.4 сая ам.долларын 1,524.8 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 109.5 сая ам.доллар буюу 4.0 хувиар буурсан ч, биет хэмжээгээр 71.5 мян.тн буюу 4.9 хувиар өссөн байна. Нэг тонн зэсийн 2023 оны дундаж үнэ 8,508.4 ам.доллар байсан бөгөөд зэсийн баяжмалыг 99.9 хувийг БНХАУ руу экспортолсон байна.

**3.Нефть:** 2023 оны IV улирлын байдлаар 4.7 сая баррельд хүрч 364.7 сая ам.долларын экспортын орлого олсон байна. 2023 оны 12 дугаар сард түүхий нефтийн экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 80.8 хувиар өссөн бөгөөд экспортын орлогын хувьд 364.7 сая ам.долларт хүрч 50.8 хувиар өсчээ. Харин түүхий нефтийн экспортын дундаж үнэ 16.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**4.Төмрийн хүдэр:** 2023 оны IV улирлын байдлаар 444.8 сая ам.долларын 5,712.9 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 53.7 сая ам.доллар буюу 13.7 хувиар, биет хэмжээгээр 980.7 мян.тн буюу 20.7 хувиар тус тус өссөн байна. Нэг тонн төмрийн хүдэрийн 2023 оны дундаж үнэ 88.5-106.5 ам.доллар байсан. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**5. Алт:** 738.0 сая ам.долларын 11,733.6 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 389.4 сая ам.доллар буюу 34.5 хувиар, биет хэмжээгээр 7,926.7 кг буюу 40.3 хувиар тус тус буурсан байна. Нэг тонн алтны 2023 оны дундаж үнэ 214,495.0 ам.доллар байсан. Алтны 89.8 хувийг Швейцар, 10.2 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна. хэвийн урсгалд нөлөөлж байна.

### **Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн**

Нийт импортын **23.1** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **76.9** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **2,140.3** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 180.0 сая ам.доллараар буюу 8.4 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **7,112.2** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 368.1 сая ам.доллар буюу 5.2 хувиар өссөн байна.

**Хүснэгт 5. Эрдсийн бүтээгдэхүүний импорт**
*/сая ам.доллар/*

Үзүүлэлт	I улирал				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	1,007.2	1,338.6	1,960.3	2,140.3	180.0	8.4	23.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	4,291.7	5,510.1	6,744.1	7,112.2	368.1	5.2	76.9
<b>Нийт импорт</b>	<b>5,298.9</b>	<b>6,848.6</b>	<b>8,704.4</b>	<b>9,252.5</b>	<b>548.1</b>	<b>5.9</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар*

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 23.1 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 19.0 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 18.2 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 11.2 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.3 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 6. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр**
*/сая ам.доллар/*

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Бүтэц (хувиар)
		2022 оны IV улирал	2023 оны IV улирал	Сая.ам доллар	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	142.1	149.8	7.7	5.2	1.7
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	145.3	153.3	8.0	5.2	5.5
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	59.6	36.8	-22.8	(62.0)	1.0
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	781.1	698.4	-82.8	(11.9)	8.1
5	Эрдэс бүтээгдэхүүн	1,960.3	2,140.3	180.0	8.4	18.2
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	597.0	514.7	-82.3	(16.0)	6.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	345.3	359.7	14.4	4.0	3.8
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	9.3	9.5	0.3	2.8	0.1
9	Мод, модон эдлэл	81.8	79.6	-2.2	(2.7)	0.6
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	98.1	78.5	-19.6	(25.0)	1.0
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	133.9	150.7	16.9	11.2	1.5
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	35.2	36.2	1.1	3.0	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	249.0	230.2	-18.8	(8.2)	2.1
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	7.1	8.9	1.7	19.5	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	812.8	861.0	48.2	5.6	6.5
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	1,265.0	1,761.4	496.4	28.2	17.3
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	1,696.1	1,682.1	-14.1	(0.8)	22.8
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	136.8	134.8	-2.0	(1.5)	1.9
19	Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	2.2	6.1	3.9	64.0	0.1
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	146.3	150.8	4.5	3.0	1.2
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.2	9.7	9.5	97.6	0.0
	<b>ДҮН</b>	<b>8,704.4</b>	<b>9,252.5</b>	<b>548.1</b>	<b>5.9</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар*

Манай улс дэлхийн 159 орноос гарал үүсэлтэй бараа импортлосноос ОХУ-д 28.6 хувь; БНХАУ-д 36.4 хувь; Япон-д 6.6 хувь; БНСУ-д 4.5 хувь; ХБНГУ-д 3.3 хувь; АНУ-д 3.1 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн 82.5 хувийг эзэлж байна.

### Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага 2023 оны 5,720.5 тасарсан үзүүлэлттэй байна.

тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 5,328.8

93.2 хувиар буюу 391.7 тэрбум төгрөгөөр

#### Хүснэгт 7. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 оны IV улирал	2023 оны IV улирал		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	гүйц.	төлөв.	гүйц.	зөрүү	хувь	зөрүү	хувь
<b>Нийт орлого</b>	<b>4,669.0</b>	<b>5,720.5</b>	<b>5,328.8</b>	<b>659.8</b>	<b>14.1</b>	<b>(391.7)</b>	<b>-6.8</b>
Гаалийн албан татвар	1,292.2	1,644.0	1,465.3	173.1	13.4	(178.7)	-10.9
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,723.1	3,376.5	3,158.4	435.3	16.0	(218.1)	-6.5
Архи, дарсны онцгой албан татвар	35.5	36.0	40.5	5.0	14.1	4.5	12.5
Тамхины онцгой албан татвар	141.7	163.0	146.9	5.2	3.7	(16.1)	-9.9
Шар айрагны онцгой албан татвар	9.1	8.0	8.3	(0.8)	-8.8	0.3	3.8
Суудлын автомашины онцгой албан татвар	281.8	290.0	321.0	39.2	13.9	31.0	10.7
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	88.3	100.0	13.2	(75.1)	-85.1	(86.8)	-86.8
Автобензин, дизель түлшний албан татвар	19.4	20.0	21.6	2.2	11.3	1.6	8.0
Экспортын татвар	0.019	-	0.040	0.0	110.5	0.040	100.0
<b>Татварын Дүн</b>	<b>4,591.1</b>	<b>5,637.5</b>	<b>5,175.2</b>	<b>584.1</b>	<b>89.1</b>	<b>(462.3)</b>	<b>-8.2</b>
Өөрийн орлого	15.8	18.0	30.0	14.2	89.9	12.0	66.7
Хураамж	62.1	65.0	123.5	58.5	98.9	58.5	90.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 659.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс:

- Гаалийн албан татвар 173.1 тэрбум төгрөг,
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар 435.3 тэрбум төгрөг,
- Архи дарсны онцгой албан татвар 5.0 тэрбум төгрөг,
- Тамхины онцгой албан татвар 5.2 тэрбум төгрөг,
- Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 2.2 тэрбум төгрөг,
- Суудлын автомашины онцгой албан татвар 39.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Харин автобензин, дизель түлшний онцгой албан татвар 75.1 тэрбум төгрөг, шар айрагны онцгой албан татвар 0.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

## Тав. Татварын чөлөөлөлт

2023 оны IV улирлын байдлаар нийт 2,027.3 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлсөн. Макро эдийн засгийн тооцооллоор импортын 5.0 хувийг татвараас чөлөөлөгдөх импорт бүрдүүлнэ. Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт

импортод эзлэх хувь 6.4 хувь хүрсэн нь макро тооцооллоос 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 8. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 оны IV улирал	2023 оны IV улирал	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	25,300.6	29,797.84	4497.2	117.8%
Эзлэх хувь	97.1%	93.6%	-3.5%	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	1,894.8	2,027.26	132.4	107.0%
Эзлэх хувь	2.9%	6.4%	3.5%	
Нийт импорт	27,195.5	31,825.1	4,629.6	117.0%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын бүтцийг харахад 2023 онд нийт импортод татвартай импорт 93.6 хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ 6.4 хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 4497.2 тэрбум төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт 132.4 тэрбум төгрөгөөр буюу 7.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## Зургаа. Татварын хойшлуулалт

- Засгийн газрын 2022 оны 335 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Шивээхүрэн боомтын чингэлэг тээврийн терминалын төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Эрчим хүчний сайд, “Шивээхүрэн терминал” ХХК, “Нарийн сухайт эрчим” ХХК-ны хооронд 2023 оны 04 сарын 07-ны өдөр 25/Г-27/2033/012-23/А/2023-13/ тоот гэрээ хийгдэж Нарийн сухайт ХХК нь гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжөөс 9.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий тоног төхөөрөмжийг импортолж 1.5 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.
- 2016 оны 10-р тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Уул уурхайн сайд, “Монголын алт” ХХК, “Эрдэнэс цагаан суврага” ХХК-ны хооронд 2023 оны 05 сарын 09-ны өдөр 41,20,195-2323/0012-5123 тоот гэрээний дагуу Эрдэнэс цагаан суврага ХХК нь гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжийн үнийн дүнд ногдуулсан 13.5 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.



## **Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийнд орсон нэмэлт, өөрчлөлт:**

**1.** Цахилгаан, дулааны эрчим хүчний 5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэр барих, суурилагдсан хүчин чадлыг өргөтгөх хүрээнд дээрхи хуулийн 40.5-т 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлөх тухай хууль батлагдсан. Үүнтэй холбогдуулан Төв аймаг, Баянжаргалан сумын Бөөрөлжүүтэд байршилтай, 30 га талбай бүхий 300МВт-ын цахилгаан станцын нийт 37.1 сая ам.долларын үнийн дүн /татвар-19.9 тэрбум төгрөг/ бүхий барилга угсралтын холбогдох төнөг төхөөрөмж, бараа материалиуд Сайншанд дахь гаалийн газрын гаалийн баталгаат барилгын талбайд байна. /Нийт тухайн цахилгаан станцын хөрөнгө оруулалтын дүн 500 сая ам.доллар болно.

**2.** Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгох хүрээнд дээрхи хуулийн 40.4-т татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах тухай хууль батлагдсан. Өнөөдрийн байдлаар 2 ААНБ татвараас хойшлуулах хүсэлтээ ирүүлээд байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**